

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/012/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням  
Утас:261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)  
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: А.Даваадорж  
Утас: 261628 Цахим хаяг: [davaadorja@audit.gov.mn](mailto:davaadorja@audit.gov.mn)  
Аудитор: М.Ганбаатар  
Утас: 261628 Цахим хаяг: [ganbaatar.m@audit.gov.mn](mailto:ganbaatar.m@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ, ЦААЗЫН  
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

2025.04.25 № 1608  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Прокурорын байгууллагын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 5,000.0 сая төгрөгөөр албан тасалгааны тавилга, серверийн тоног төхөөрөмж болон хэргийн газрын үзлэг, шүүх хуралдаан болон бусад мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын аюулгүй байдлыг хангахад ашиглагдах тээврийн хэрэгслийн парк шинэчлэлтийг хийх зорилгоор нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны “Хөрөнгө бүртгэх тухай” А/84, А/165, А/166 тоот тушаалуудаар харьяа газруудад шилжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 934.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн нэмэгдэл олгоход 218.4 сая төгрөг, багаж тоног төхөөрөмж худалдан авахад 116.2 сая төгрөг, тавилга эд хогшил худалдан авахад 20.0 сая төгрөг, 579.5 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад баталсан Архангай аймгийн прокурорын газрын конторын барилга 4,874.5 сая төгрөг, Хэнтий аймгийн прокурорын газрын барилга 5,384.9 сая төгрөг, Баянгол дүүргийн прокурорын газрын конторын барилга 5,732.5 сая төгрөг нийт 15,991.8 сая төгрөгийн барилгын ажлууд дуусгавар болж, улсын комисс хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 618 тоот тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Их хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр"-ийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны А/58 тоот тушаалаар Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст "Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх алба"-ыг 27 орон тоотойгоор аймаг, нийслэлийн прокурорын газруудад байгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 64 зорилтын хүрээнд нийт 144 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 93.7 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан***Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	27,402,585.4	22,310,490.1
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,778,162.8	4,834,432.9
33	<b>АВЛАГА</b>	79,288.4	586,872.3
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	117,430.5	169,406.1
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,344,553.2	2,836,759.0
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	23,083,150.6	13,883,019.8
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	56,853,390.4	75,583,016.0
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	56,853,390.4	75,583,016.0
39200	<b>Биет хөрөнгө</b>	52,568,750.8	71,303,784.5
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	4,284,639.6	4,279,231.5
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	84,255,975.8	97,893,506.1
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	1,003,319.2	4,037,381.3
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	888,551.8	3,949,317.4
41300	<b>Өглөг</b>	17,879.0	49,630.0
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	870,672.9	3,899,687.4
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	114,767.3	88,063.9
42200	<b>Урт хугацаат зээл</b>	114,767.3	88,063.9
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	83,252,656.6	93,856,124.8
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	83,252,656.6	93,856,124.8
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	16,767,153.6	16,772,925.2
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	61,759,968.4	72,363,036.7
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	4,725,534.5	4,720,163.0
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	84,255,975.8	97,893,506.1

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,030,039.9	111,812,548.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,515,688.1	1,140,177.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,515,688.1	1,140,177.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,514,351.8	110,672,371.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,469,839.6	101,531,315.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,469,839.6	101,531,315.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,361,130.6	92,548,832.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,098,585.0	68,217,822.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,788,875.6	8,539,205.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,442,301.6	1,700,190.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,439,631.4	2,674,356.2
2105	Норматив зардал	18,056.1	121,061.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,724,360.4	1,888,212.4
2107	Томилолт, зочны зардал	351,531.8	386,540.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	955,917.9	1,816,104.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,541,870.9	7,205,339.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,108,709.0	8,982,483.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,560,200.2	10,281,233.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,200.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	70,622.0	166,544.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	12,490,778.3	10,114,689.1

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	74,084,203.70	113,992,112.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,558,123.80	3,319,740.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,558,123.80	3,319,740.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,526,079.80	110,672,371.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,187,023.90	98,865,500.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,187,023.90	98,865,500.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,702,329.80	89,634,850.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,113,725.60	68,266,244.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,789,217.50	8,520,408.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,442,398.50	1,706,643.60
2104	Хангамж, бараа материалын зардал	2,337,951.30	2,487,205.50
2105	Норматив зардал	200,725.40	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,777,845.80	3,719,991.40
2107	Томилолт, зочны зардал	343,760.40	395,822.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,367.90	2,227,438.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,586,337.50	2,111,095.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,484,694.00	9,230,649.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,897,179.80	15,126,612.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,189,056.20	12,076,382.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,189,056.20	12,076,382.30
2200	Дотоод эх үүсвэрээр	15,189,056.20	12,076,382.30
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,189,056.20	-12,076,382.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-207.1	40.2
14	Бусад эх үүсвэр	160	226.6
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	367.1	186.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,292,083.60	3,050,270.20
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,070,246.30	1,778,162.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,778,162.80	4,834,432.90

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан***Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,512,793.8	0.0	70,512,793.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	75,316.8	0.0	75,316.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,588,110.6	0.0	70,588,110.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,823.6	0.0	-1,823.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	175,591.4	0.0	175,591.4
9	Тайлант үеийн үр дүн	12,490,778.3	0.0	12,490,778.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,252,656.6	0.0	83,252,656.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	83,252,656.6	0.0	83,252,656.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	488,379.1	0.0	488,379.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,741,035.7	0.0	83,741,035.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	400.0	0.0	400.0
19	Тайлант үеийн үр дүн	10,114,689.1	0.0	10,114,689.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	93,856,124.8	0.0	93,856,124.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон  
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>110,621,127,100.00</b>	<b>101,924,490,518.77</b>	8,696,636,581.23	92.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>99,272,827,100.00</b>	<b>90,881,088,097.77</b>	8,391,739,002.23	91.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>97,730,596,500.00</b>	<b>89,906,188,684.15</b>	7,824,407,815.85	92.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>74,111,313,900.00</b>	<b>68,020,511,715.04</b>	6,090,802,184.96	91.8
210101	Үндсэн цалин	39,727,523,300.00	38,407,340,597.26	1,320,182,702.74	96.7
210102	Нэмэгдэл	21,253,078,700.00	19,530,643,310.85	1,722,435,389.15	91.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,300,966,600.00	4,474,097,617.00	826,868,983.00	84.4
210104	Урамшуулал	7,798,745,300.00	5,575,358,311.93	2,223,386,988.07	71.5
210105	Гэрээт ажлын хөлс	31,000,000.00	33,071,878.00	-2,071,878.00	106.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,263,914,200.00</b>	<b>8,497,068,261.14</b>	766,845,938.86	91.7
210201	Тэтгэврийн даатгал	6,235,086,600.00	5,809,411,030.01	425,675,569.99	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	805,488,200.00	689,716,503.89	115,771,696.11	85.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	370,555,300.00	342,301,891.19	28,253,408.81	92.4
210204	Ажилгүйдлийн даатгал	370,557,800.00	330,920,792.08	39,637,007.92	89.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,482,226,300.00	1,324,718,043.97	157,508,256.03	89.4
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,003,482,900.00</b>	<b>1,706,643,631.22</b>	296,839,268.78	85.2
210301	Гэрэл, цахилгаан	586,715,400.00	484,618,218.36	102,097,181.64	82.6
210302	Түлш, халаалт	1,210,696,200.00	1,024,793,708.80	185,902,491.20	84.6
210303	Цэвэр, бохир ус	176,440,300.00	172,902,166.06	3,538,133.94	98.0
210304	Байрны түрээс	29,631,000.00	24,329,538.00	5,301,462.00	82.1
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,600,035,300.00</b>	<b>2,482,415,483.98</b>	117,619,816.02	95.5
210401	Бичиг хэрэг	783,378,200.00	771,435,936.00	11,942,264.00	98.5
210402	Тээвэр, шатахуун	654,551,500.00	628,780,328.92	25,771,171.08	96.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,873,700.00	472,668,978.81	57,204,721.19	89.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	59,644,700.00	42,402,845.00	17,241,855.00	71.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	572,587,200.00	567,127,395.25	5,459,804.75	99.0
2105	<b>Норматив зардал</b>	<b>200,775,100.00</b>	<b>200,000,000.00</b>	775,100.00	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,775,100.00	200,000,000.00	775,100.00	99.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,222,897,900.00</b>	<b>4,189,124,955.50</b>	33,772,944.50	99.2

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,375,130,000.00	1,370,829,971.00	4,300,029.00	99.7
210602	Тавилга	920,200,000.00	919,718,170.00	481,830.00	99.9
210604	Урсгал засвар	1,927,567,900.00	1,898,576,814.50	28,991,085.50	98.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>374,536,000.00</b>	<b>359,033,038.00</b>	15,502,962.00	95.9
210702	Дотоод албан томилолт	374,536,000.00	359,033,038.00	15,502,962.00	95.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,369,249,400.00</b>	<b>2,278,948,105.75</b>	90,301,294.25	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,008,910,800.00	1,939,525,366.97	69,385,433.03	96.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,356,000.00	5,912,000.00	444,000.00	93.0
210803	Даатгалын үйлчилгээ	108,042,000.00	105,619,374.00	2,422,626.00	97.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	19,978,900.00	11,530,872.78	8,448,027.22	57.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,578,000.00	2,221,765.00	356,235.00	86.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	184,667,300.00	179,937,762.00	4,729,538.00	97.4
210807	Газрын төлбөр	38,716,400.00	34,200,965.00	4,515,435.00	88.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,584,391,800.00</b>	<b>2,172,443,493.52</b>	411,948,306.48	84.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,721,926,800.00	1,637,997,817.02	83,928,982.98	95.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	862,465,000.00	534,445,676.50	328,019,323.50	62.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,542,230,600.00</b>	<b>974,899,413.62</b>	567,331,186.38	63.2
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,542,230,600.00</b>	<b>974,899,413.62</b>	567,331,186.38	63.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,121,424,000.00	555,144,113.62	566,279,886.38	49.5
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,195,000.00	39,091,000.00	104,000.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	381,611,600.00	380,664,300.00	947,300.00	99.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,348,300,000.00</b>	<b>11,043,402,421.00</b>	304,897,579.00	97.3
220001	Барилга байгууламж	6,348,300,000.00	6,348,028,473.00	271,527.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	5,000,000,000.00	4,695,373,948.00	304,626,052.00	93.9

<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>110,621,127,100.00</b>	<b>101,924,490,518.77</b>	8,696,636,581.23	92.1
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>110,621,127,100.00</b>	<b>101,911,301,932.52</b>	8,709,825,167.48	92.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	110,621,127,100.00	101,911,301,932.52	8,709,825,167.48	92.1
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0</b>	<b>13,188,586.25</b>	-13,188,586.25	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	13,188,586.25	-13,188,586.25	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>41</b>	<b>41</b>	-	100.0
610001	Төсвийн байгууллага	41	41	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1502</b>	<b>1397</b>	105	93.0
620001	Удирдах ажилтан	53	53	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	964	861	103	89.3
620003	Үйлчлэх ажилтан	485	483	2	99.6
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1502</b>	<b>1397</b>	105	93.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	308	278	30	90.3
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2	2	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	483	482	1	99.8
650012	Шүүгч, прокурор	709	635	74	89.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>934,152,579.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>934,152,579.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>881,530,905.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>195,090,962.66</b>
210101	Үндсэн цалин		9,103,740.84
210102	Нэмэгдэл		106,340,728.86
210104	Урамшуулал		69,171,478.96
210105	Гэрээт ажлын хөлс		10,475,014.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>23,340,018.92</b>
210201	Тэтгэврийн даатгал		17,521,677.76
210202	Тэтгэмжийн даатгал		1,541,704.61
210203	ҮОМШӨ-ний даатгал		770,850.29
210204	Ажилгүйдлийн даатгал		701,156.61
210205	Эрүүл мэндийн даатгал		2,804,629.65
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>4,765,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун		3,265,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>146,619,124.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		116,219,124.00
210602	Тавилга		20,000,000.00
210604	Урсгал засвар		10,400,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>36,789,700.00</b>
210702	Дотоод албан томилолт		36,789,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>341,398,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		327,548,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		13,850,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>133,527,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		100,876,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		32,651,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>52,621,674.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>23,167,619.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		23,167,619.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>29,454,055.20</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		29,454,055.20
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>934,152,579.78</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>934,152,579.78</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		689,964,108.78
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		244,188,471.00

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 3,347.1 сая төгрөгийн 39 алдаа<sup>1</sup> илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 218.2 сая төгрөгийн 31 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 18.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 199.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 28 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 44 байгууллага, ахмадын сан, хөрөнгө оруулалтын данс хамрагдсанаас, 15 байгууллага аудитын түүвэрт хамрагдаж, 29 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан 29 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 335.7 сая төгрөгийн зөрчил илэрч давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 335.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 279.7 сая төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/сая төгрөгөөр/*

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ</b>												
МУЕП нэгтгэсэн тайлан	2	600.3			2	600.3	2	600.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>600.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>600.3</b>	<b>2</b>	<b>600.3</b>				
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>												
УЕПГ-ын тамгын хэлтэс	1	2,217.2			1	2,217.2	1	2,217.2				
Нийслэлийн прокурорын газар	3	185.9			3	185.9	3	185.9				
Баянгол дүүргийн прокурорын газар	1	0.5	1	0.5			1					
Баянзүрх дүүргийн прокурорын газар	2	23.1			2	23.1	2	23.1				
Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	2	34.0			2	34.0	2	34.0				
Сүхбаатар дүүргийн прокурорын газар	7	77.6			7	77.6	7	77.6				
Хан-Уул дүүргийн прокурорын газар	1	6.0			1	6.0	1	6.0				
Чингэлтэй дүүргийн прокурорын газар	2	38.8			2	38.8	2	38.8				
Багануур дүүргийн прокурорын газар	4	32.2			4	32.2	4	32.2				
Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	2	55.2			2	55.2	2	55.2				
Булган аймгийн прокурорын газар	1	3.0			1	3.0	1	3.0				
Говь-Алтай аймгийн прокурорын газар	3	21.1	1	5.0	2	16.1	3	16.1				
Говь-сүмбэр аймгийн прокурорын газар	1	0.3			1	0.3	1	0.3				
Дархан-Уул аймгийн прокурорын газар	1	3.9			1	3.9	1	3.9				
Дундговь аймгийн прокурорын газар	3	31.2	2	30.5	1	0.7	3	0.7				
Завхан аймгийн прокурорын газар	1	0.8			1	0.8	1	0.8				
Орхон аймгийн прокурорын газар	1	15.6			1	15.6	1	15.6				
Сэлэнгэ аймгийн прокурорын газар	1	0.4	1	0.4			1					
<b>Дүн</b>	<b>37</b>	<b>2,746.8</b>	<b>5</b>	<b>36.4</b>	<b>32</b>	<b>2,710.4</b>	<b>37</b>	<b>2,710.4</b>				
<b>Нийт дүн</b>	<b>39</b>	<b>3,347.1</b>	<b>5</b>	<b>36.4</b>	<b>34</b>	<b>3,310.7</b>	<b>39</b>	<b>3,310.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ</b>								
МУЕП-н хөрөнгө оруулалтын данс	1	117.5					1	117.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>117.5</b>					<b>1</b>	<b>117.5</b>
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>								
УЕПГ-н тамгын хэлтэс	3	60.2			1	16.6	2	43.6
Нийслэлийн прокурорын газар	3	44.6					3	44.6
Баянгол дүүргийн прокурорын газар	1	0.5					1	0.5
Баянзүрх дүүргийн прокурорын газар	1	11.5					1	11.5
Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	1	24.1					1	24.1
Сүхбаатар дүүргийн прокурорын газар	3	15.8					3	15.8
Чингэлтэй дүүргийн прокурорын газар	3	22.5					3	22.5
Багануур дүүргийн прокурорын газар	3	12.3					3	12.3
Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	2	12.7					2	12.7
Булган аймгийн прокурорын газар	2	0.1	1	0.1			1	-
Говь-сүмбэр аймгийн прокурорын газар	1	-					1	
Дархан-Уул аймгийн прокурорын газар	2	10.6					2	10.6
Дорноговь аймгийн прокурорын газар	1	-					1	
Орхон аймгийн прокурорын газар	3	1.6			1	1.6	2	-
Сэлэнгэ аймгийн прокурорын газар	1	1.3					1	1.3
Төв аймгийн прокурорын газар	1	0.4					1	0.4
<b>Дүн</b>	<b>31</b>	<b>218.2</b>	<b>1</b>	<b>0.1</b>	<b>2</b>	<b>18.2</b>	<b>28</b>	<b>199.9</b>
<b>Нийт дүн</b>	<b>32</b>	<b>335.7</b>	<b>1</b>	<b>0.1</b>	<b>2</b>	<b>18.2</b>	<b>29</b>	<b>317.4</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ</b>								
МУЕП-н эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд	1	-					1	-
Говь-сүмбэр аймгийн прокурорын газар	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ</b>								
МУЕП-ын хөрөнгө оруулалтын данс	1	-					1	-
Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтэс	1	-					1	-
Нийслэлийн прокурорын газар	1	121.9					1	121.9
Баянгол дүүргийн прокурорын газар	1	16.0					1	16.0
Баянзүрх дүүргийн прокурорын газар	1	112.8					1	112.8
Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	1	52.9					1	52.9
Сүхбаатар дүүргийн прокурорын газар	1	16.4					1	16.4
Хан-Уул дүүргийн прокурорын газар	1	10.6					1	10.6
Чингэлтэй дүүргийн прокурорын газар	1	26.7					1	26.7
Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	1	1.1					1	1.1
Хөвсгөл аймгийн прокурорын газар	1	9.9					1	9.9
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>368.3</b>					<b>11</b>	<b>368.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>13</b>	<b>368.3</b>					<b>13</b>	<b>368.3</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	44	29	15		29			
2	ТЕЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>45</b>	<b>30</b>	<b>15</b>		<b>30</b>			